

ХУУЛЬ БУС ОРШИН СУУГЧДЫН МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА АСУУДЛУУД: МОНГОЛ АЖИЛЧДЫН БЭРХШЭЭЛ¹²

ШИМ ҮЙ СОБ, Г.Мөнхнасан

< Abstract >

Since the Korea traditional homogeneous community is now opening to the multi-ethnic society, the various social services including the financial services are providing the foreigners. Even the illegal Mongolian workers can send their salary through the banks to their family in hometown. For the bank cooperation Mongolian Khaan Bank signed with Korean banks such as Kookmin Bank, Shinhan Bank and Korea Exchange Bank (KEB). The Mongolian partner banks for remit are Trade Development Bank, Mongol Shuudan Bank, Anod Bank, Golomt Bank and Credit Bank. To see the remittance of Mongolian workers the average amount of money per person is 800-1000 thousand K\\$. The number of Mongolians every weekend to use each branch window to remit are 100~110 persons for KEB, 60~70 persons for Shinhan Bank and 10 persons for Kookmin Bank. Still there are many problems to be solved such as 1) small amount of remit for both each time and year base, 2) the remittance are using commonly inefficient way in Mongolia, 3) impossible services for the person with no IDs, 4) impossible services for the persons cannot speak Korean and living in rural area, and 5) impossible services for industrial trainees whose pass port deposited to the factory boss for safety. For further development of financial cooperation to increase the efficiency between

¹² Энэхүү илтгэл Солонгос монгол судлалын Олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавигдаж, засварлагдсан болно. Санжи их сургууль, Уонжу, БНСУ, 2007. 2. 15-16

Korea and Mongolia the micro-financing and Korea Won Recycling should studied and suggested.

1. “НЭГ САЯ” ГАДААДЫНХНЫ ЦАГ ҮЕ БА ХУУЛЬ БУСААР АМЬДРАГЧИД

Солонгост амьдарч буй гадаадын хүмүүсийн тоо 1 сая давж, нийт хүн амын 2%-ийг эзлэх болжээ. Улсын хэмжээгээр арван мянгаас дээш гадаадын хүн амьдарч буй хот, дүүрэг, хороо 8 болж (зураг 1), Сөүлд амьдрах гадаадын хүмүүс 160 мянгад хүрчээ. 1990 он хүртэл Ичун хорооны Япончуудын тосгон, Банху хорооны зүүний орнуудаас ирэгсдийн тосгон гэх зэргээс өөр газарт гадаадынхан байгаагүй бөгөөд 2000 онд гарахад хөгжиж байгаа орнуудын ажилчид бөөн бөөнөөрөө орж ирсээр орос, төв ази, хятадын солонгосчуудын тосгон бий болж, монгол, непал, филиппин, нигер гудамж хүртэл гарч ирсэн. Франц тосгон нь зүүний орнуудаас ирэгсдийн тосгон бөгөөд Ичун хорооны Япон тосгон зэрэг өндөр хөгжилтэй орноос ирэгсдийн тосгонууд өндөр зэрэглэлийн орон сууцны хороолол болж, хөгжиж буй орнуудын тосгонуудын зарим нь ядуусын хороолол болох түгшүүр байна.

Хөгжиж буй орнуудаас ирсэн ажилчдын цугладаг газруудаас гол газар нь Карибуны хятадын солонгосчуудын таун (Ёнбён гудамж) юм. 1990-ээд оны эхний хагаст Күрү үйлдвэрийн цогцолборын үйлдвэрүүд захын дүүрэг рүү шилжиж, хятадын солонгосчууд сард 100-200 мянган воны жижигхэн өрөөнд нийтээрээ амьдарсан нь үүний эхлэл юм. Түндэмүн спортын хүрээлэнгийн метроны буудлын орчимд Куанхи дүүргийн нэгэн хэсэгт монгол хүмүүсээр дүүрсэн Монгол Таун гэж нэрлэдэг Ньюгимху барилгад төвлөрдөг. Чунну дүүргийн Чаншинь хорооны Непалчуудын гудамж нь 2000 онд нээгдэн непал хоолны газар Намастед төвлөрөн бүрддэг. Монгол Тауны хажууд төв ази тосгон байдаг бөгөөд Сөүлийн олимпын дараа орос, төв азийн үүргийн худалдаачид Түндэмүн дэх хувцасны захаар орж гарсаар бий болгосон. Хехуа хороо Тэханнуд бүтэн сайн өдөр болоход Католигийн сүмд төвлөрсөн жижиг Манилла бий болдог. Юнсан дүүргийн Итэвонь хороонд Мусламын гудамж ба Нигерийн гудамж байдаг. 1976 онд Исламын төв бий болж энэтхэг, пакистан зэрэг мусламчууд Итэвоны метроны буудлын ойролцоо цугларч эхэлсэн. Сүүлийн үед нигерчууд цугларан африк тосгон бүрдэж байна. Ёнхи хорооны Хятад таунд 3500 орчид хятад хүмүүс амьдарч байна. Сөүлд амьдарч буй хятадын 7500 хүний тэн хагас орчим нь энд бөөгнөрч байна. (Төв Sunday, 2007.07.08)

Олон үндэстний нийгмээр солигдож байгаа нь ганцхан солонгосын байдал ч биш юм. Төрөлт багасах, өндөр настнууд ихэсч байгаагаас ажиллах хүчин дутагдах асуудал даган гарч ирж улс бүрд мэргэжлийн гадаад ажилчдыг нэмэгдүүлэх өрсөлдөөн гарч ирсэн юм. Гадаадын хүний ялгаварлалыг арилгах нь бодлогын түвшинд ч зогсохгүй өсвөр насныхны сургалт, улс төрийн оролцооны асуудал хүртэл сэтгэл зовоох түвшинд байна. (Мүнхуа илбу, 2007.10.02)¹⁵

2006 онд Швейцарийн Олон улсын менежментийн хөгжлийн хүрээлэнгийн дэлхийн улсуудын өрсөлдөх чадварын судалгаанаас харвал Солонгос улс нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах асуудалтай холбоотой судалгаанд хамрагдсан 55 улсаас 51-р байранд оржээ. НҮБ-ын арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг халах зөвлөлөөс, мөн 2007 оны 7 сард Солонгос улсын тухайд нэг үндэстнийг дагасан арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийг халахыг сануулсан байна. (Мүнхуа илбу, 2007.10.02) НҮБ-ын арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг халах зөвлөл “Өмнөд солонгос улс нь нэг үндэстнийг онцолж байгаа нь олон улсын түвшнээс харахад арьс өнгөөр ялгаварлан гадуурхахад хамаарч байна” гэсэн бөгөөд “Өмнөд солонгост энгийнээр хэрэглэж байгаа цэвэр цус, холимог цус зэрэг үгс ч арьс өнгөний давуу үзлийг илрүүлж байна” гэж шүүмжилсэн байна.¹⁶

2. Хууль бусаар амьдрагчдад зориулсан мөнгөн гуйвуулах үйлчилгээ

Гадаадын цагаачлагчид нэмэгдэн тэдний өөрийн орон руу мөнгө гуйвуулах асуудал нь олон янзын аюул, бэрхшээлийг агуулж байна. Дэлхийд алдартай гадаадын мөнгөн гуйвуулгын байгууллага болох Америкийн “Уэстэрн юнион” (Western Union) нь санхүүгийн аюулаас үл эмээн ихэнх гадаадад цагаачлагчдын эх орондоо мөнгө гуйвуулах ажлыг шийдвэрлэж өгч байна. Энэ банк нь одоо дэлхийд 320 мянга орчим цэгтэй¹⁷ бөгөөд улс бүрийн супермаркетын сүлжээ болон шуудан зэрэгтэй хамтран цагаач ажилчдад эх оронд нь мөнгө гуйвуулах зэргээр жилд тэрбум доллараар ашгаа нэмэгдүүлж байна. Энэ банк шуурхай байдлаараа

¹⁵ Япон том хэмжээний улсын төсөл “Э-Япон”-ыг хэрэгжүүлж солонгос зэрэг дээд зэрэглэлийн гадаадын ажиллах хүчийг өргөхөд хүчээ тавьж байна. Гадаадын ажилчдын хүүхдүүдэд мэргэжлийн удирдагч томилох, сургуулийн хичээлийн агуулгыг эх хэл дээр нь тайлбарлан өгч гадаадынханд сонгох эрхийг хүлээн зөвшөөрч байгаа орон нутгийн бие даасан байгууллагууд ч нэмэгдэж байна. Сингапур нь америк, япон зэрэг 8 өндөр хөгжилтэй орны 1 сая орчим гадаадын чадварлаг ажиллах хүчний хувийг 5 жилийн дотор 2 дахин ихэсгэх төлөвлөгөөтэй байна. Тайвань гадаадын ажилчдын визийн журмыг зөөлрүүлж гадаадынхны таун байгуулах зэрэг олон янзийн дэмжлэгийн арга хэмжээг бэлтгэж байна.

¹⁶ Солонгос ба ази хүний дундаас төрсөн 2 настай, эсвэл ази цагаач ажилчдын хүүхдүүдийг нэрлэдэг Кушнан (Кореа+Ази) гэдэг илэрхийлэл маргааныг бий болгож байна. Гадаадынхантай хуримлагсдын хүүхдүүд ба цагаач хүүхдүүдийн хүний эрх ба эрх ашгийг хамгаалахын тулд бий болсон үг боловч сүүлийн үед бас ялгаварлан гадуурхах үгээр хэрэглэж байгаагаас болж байна.

¹⁷ Энэ хэмжээ нь Макдональд, Старбукс, Бургеркин, Уолмартын худалдааны цэгийг бүгдүүийг нь нийлүүлснээс 5 дахин их байна.

алдартай бөгөөд Нью-Йоркоос илгээсэн мөнгийг хоногийн дараа филиппинээс авч чадах үйлчилгээг хийж байна. (Ханагёре, 2007.11.23)

Энэ компани мөн 4-20% хүртэл мөнгөн гуйвуулгын шимтгэл хэт өндөр ба валютын ханшаар мэхлэн асар их хэмжээний ашгийг шудрага бусаар олж байна гэсэн шүүмжлэлд ч өртөж байсан¹⁸. Гэсэн ч энэ компани нь хууль бус амьдарч ажиллагчдын хуулийн дэмжлэгт их хэмжээний зардлаар хөрөнгө оруулж байна. Учир нь үйлчлүүлэгчдийн ихэнх нь хууль бус амьдрагчид юм. Ямар ч байсан “Уэстэрн юнион” америкийн гадаад мөнгөн гуйвуулгын тэргүүн байрыг эзэлж үүний талаар олон янзийн үзэл бодол гарч байна. “Уэстэрн юнион нь зах зээлийн эзэмшлийн хувиа нэмэгдүүлэхийн тулд хууль бусаар амьдрахыг өдөөж байна” гэсэн шүүмжлэл байхад “Ядуу хүмүүст яг хэрэгтэй бөгөөд дуртайяа мөнгө төлөхөөр үйлчилгээг үзүүлж байна” гэсэн няцаалт ч бас байна. 2006 онд гадаадад цагаачлагчдын эх орондоо гуйвуулсан мөнгөний хэмжээ нь дэлхийн хэмжээгээр 300 тэрбум долларт хүрч энэ нь дэлхийн гадаадын тусламжийн төсвийн нийт хэмжээнээс 3 дахин их хэмжээнд дөхөж байна.

Хүснэгт 1. “Уэстэрн юнион”-ий гадаадын цагаачлагчдын эх орондоо гуйвуулсан мөнгөний хэмжээ (2006)

Хэмжих нэгж: зуун сая доллар	
Улс	Гуйвуулсан мөнгөний хэмжээ
Энэтхэг	245.0
Мексик	242.5
Хятад	210.7
Филиппин	146.5
Орос	137.9
Узбекистан	84.7
Бангладеш	81.1
Турк	74.8
Бразил	73.7
Вьетнам	68.2
Хойд Солонгос	18.0

Эх үүсвэр: : Inter American Dialogue, Ханагёре, 2007.11.23

Хууль бусаар амьдрагчдын мөнгөн гуйвуулгын бэрхшээл Солонгост байгаа монгол ажилчдад ч гарч байна. 2005 оны 9 сард монголын банкнуудын солонгос дахь хууль бус үйлчилгээг санхүүгийн хяналтын байгууллага зогсоож, тухайн үеийн их хэмжээний хадгаламж зэрэг бэлэн мөнгийг солонгосын санхүүгийн хяналтын байгууллага хураан авч байсан.¹⁹ Солонгосын хууль журмыг дагавал ийм мөнгийг шууд улсын эзэмшилд хураан авч болох боловч хоёр улсын найрамдалт найрсаг харилцаа ба

¹⁸ Гэвч энэ компани “Цагаачдын итгэж болох найз” гэсэн имижийг ойлгуулахыг чармайж байна. Жишээлбэл: Фижи арлынхны тусгаар тогтнолын өдөр зэрэг хүмүүсийн сайн мэддэггүй жижигхэн орнуудын баяр ёслолыг нь үлдээлгүй тухайн газарт зарлах ба ядуу орнуудын ажилчдад зориулсан арга хэмжээг дэмжиж байна.

¹⁹ Тэр үед 900 сая воныг хурааж авсан.

солонгост оршин суух монголын элчин сайдын яамны элэгсэг хүсэлтийн дагуу бүгдийг нь эргүүлэн өгч тусгайлан үзсэн юм.

Түүний дараа Солонгост оршин суух монголын элчин сайдын яам нь 2005 оны 9 сард Солонгосын Санхүүгийн хяналтын байгууллагатай мөнгөн гуйвуулгын талаар зөвшилцсөн бөгөөд солонгосын Шинхан банктай хамтрах хүсэлт гаргасан. Түүний үр дүнд Шинхан банкны бүх салбарууд монгол хэлээр боловсруулсан мөнгө хүлээн авах мэдүүлгийг бэлдэхээр болж шимтгэлийн хэмжээг ч хамгийн багаар тогтоож өгсөн.²⁰

Дараа нь Монголын арилжааны банкныхан Сөүлд зөвшөөрөлгүй үйлчилгээ хийж байгаад цагдаагийн газарт бөөнөөрөө илэрсэн. (2005.11.9) Санхүүгийн хяналтын байгууллагын зөвлөлийн банкны үйлчилээний зөвшөөрөл ба санхүүгийн эдийн засгийн албанд бүртгэлгүй Сөүлийн Чүнгү дүүрэгт дэх Монгол Таунд монголын банкны сөүлийн салбарыг байгуулан 2003 оноос эхлэн 2 жил орчим хадгаламж хүлээн авах ба мөнгө гуйвуулах зэрэг хууль бус банкны ажиллагааг явуулж байжээ. Илэрсэн банкнууд нь монголын Анод банк, Кредит банк, Зоос банк, Голомт банк, Шуудан банк гэсэн 5 банк байсан юм. (Ёнхаб ньос, 2005.11.9) Шалгалтын дүнд хоорондоо өөр өөр монголын банкнуудын солонгос салбарын эрхлэгчийн эрхээр 2003 оноос хууль ёсоор орж ирэн жилд 4-6%-ийн хүү авах нөхцөлтэйгээр солонгост амьдарч буй монголын 4200 орчим хүний хадгаламжийн 12 тэрбум воныг монгол дахь банк руугаа гуйвуулсан нь гарч ирсэн.

Эдгээр нь монгол руу мөнгө гуйвуулахыг хүссэн дотоод ба гадаадын 9000 орчим хүнээс 1-1.5%-ийн гуйвуулгын шимтгэл авч мөнгө гуйвуулах хүсэлт гаргагчийн дотоодын банкны дансанд оруулсан мөнгийг монгол дахь өөрийн банкиндаа илгээх замаар 30 тэрбум воныг хууль бусаар гуйвуулсан юм. Харин үүний дараа ийм хууль бус банкны хэлбэр ба ажилчдын хохирсон жишээ багасахгүй байгаа нь голдуу харилцааны бэрхшээл, банкны мэдээллийн хомсдол, бүртгэлгүй бичиг баримтны бэрхшээлээс үүдэн гарч байгаа юм. Жишээлбэл, хохирогчдын хууль бус мөнгөн гуйвуулга нь брокерыг дамжсан мөнгөн гуйвуулга, хувийн валют солих цэгээр дамжуулсан валютын солилцоо, хүнээр дамжуулсан мөнгөн гуйвуулга, банкнаас гадаад валютын мөнгөн гуйвуулга байгаа ч үүнээс үүдэлтэй хохирол нь хэт өндөр шимтгэл, брокерын оролцоо, өндөр валютын ханш, хүргэж өгөх бэрхшээл, шимтгэлийн давхар дарамт (валют солих шимтгэл + бэлэн мөнгөний шимтгэл) зэргээр гарч байна. Нэг талаар банкны арилжаатай холбогдсон бэрхшээл нь цалин хөлсөө бэлэн мөнгөөр хадгалах, өөр хүний нэрээр данс нээлгэх, баривчлагдах, хуурамч нэр хэрэглэх зэрэг бөгөөд үүнийг даган хохирол нь хулгай, алга болж гээгдэх, булаалгах, алдагдсаныг мэдүүлсний

²⁰ 2000 доллар хүртэл 9000 воны шимтгэл төлж байх ба энэ нь банкны энгийн гуйвуулга 2000 долларт 18000 воны байгаагийн 50%-иар хөнгөлж өгч байгаа юм.

дараа алга болох зэрэг хохирол, хадгаламжийн дэвтэр, бэлэн мөнгөний карт алга болох зэргээр гарч байна.

Хууль бус мөнгөн гуйвуулгын хэргийн байдлын шалтгаанаас банкаар дамжуулсан мөнгөн гуйвуулгын систем нь хууль ёсоор суурьших хүртэлх явцыг харвал дараах байдалтай байна. (Шинхан банкны материал)

□ 2005 оны 11-р сарын 9-ны өмнө монголын хууль бусаар амьдрагч ажилчдын мөнгөн гуйвуулгын бодит байдал:

- Солонгост амьдардагч монголчууд 27000 орчим, үүний дотор хууль бус амьдрагч 15000 орчим хүн амьдарч байсан. (засгийн газрын тооцоогоор)
- Сөүлийн Чүнгү дүүрэг, Куанхи хороон дахь Монгол Тауны ойролцоо байрласан зөвшөөрөлгүй монголын банк (Анод, Кредит, Голомт, Зоос, Шуудан банк)-наас солигч, нэр зээлэгчид тулгуурласан хууль бус гуйвуулга хийсэн.
- 2005 оны 11 сарын 9 нд Банкны хууль, гадаадын валютын арилжааны хууль зөрчсөн зэрэг илэрч, мөнгөн гуйвуулга боломжгүй болсон.
- Хууль бус гуйвуулгын хэмжээ: дотоод гадаадын 9000 орчим хүний, 21 тэрбум 500 сая вон (20 ам.сая доллартай дүйцэх)
- Монголын банкаар дамжуулсан солих, бусдын нэр зээлдэхэд тулгуурласан хууль бус мөнгөн гуйвуулга.

□ 2005 оны 12-р сард Монголын элчин сайдын яамаар дамжуулан Шинхан банкны үйлчилгээний цэгүүд ба мөнгө гуйвуулах аргыг танилцуулж, 2000 доллараас доош мөнгө гуйвуулахад шимтгэл 18000→10000 вон руу буурч, монгол хэлээр гуйвуулгын мэдүүлгийг бэлтгэсэн.

□ 2006 оны 5-р сард Санхүүгийн хяналтын байгууллагын хүсэлт ба банкны захирлын тусгай заавраар шимтгэлийг нэмж бууруулан 10000→5400 вон болсон.

□ 2006 оны 5-р сард Ну Мү Хён ерөнхийлөгч Монголд албан ёсоор айлчлах явцад Монголын засгийн газраас Солонгост амьдарч буй монголчуудын эх орондоо мөнгө гуйвуулахыг хялбараар шийдэж өгөх тухай хүссэн хүсэлтийг хүлээн авсан.

- Солонгост амьдарч буй монгол 25489 хүн, монголын ДНБ-ий 10% буюу 14 тэрбум доллар, хууль бус мөнгөн гуйвуулга өссөн.
- 3 дахь үед Ерөнхий сайдын ажлын алба, Хууль зүйн яам, Гадаадынхныг дэмжих төв, Санхүү эдийн засгийн яам, Санхүүгийн хяналтын газар, Солонгос дахь монголын элчин сайдын яам, Шинхан банк, Күкмин банк, Үэхуан банк Төр засгийн газрын гүйцэтгэх албанд хуралдсан.
- Бодлогын үр дүн 1: 2006 оны 8-р сарын 3-нд гадаадын валтын арилжааны журамд өөрчлөлт: 1 удаад 1000 доллараас доош, жилд 20000 доллараас доош хязгаарын дотор орлогын нотолгоогүйгээр цалингийн гуйвуулга хийх боломжтой, хууль бус амьдрагчид мөнгө гуйвуулах боломжтой.
- Бодлогын үр дүн 2: Солонгосын 3 банк амралтын өдрүүдэд Монгол руу мөнгө гуйвуулах үйлчилгээг хийх ба монгол хэлний орчуулагч ажиллуулж, монгол хэлээр мөнгөн гуйвуулгын мэдүүлэг, танилцуулга гаргах,

- 2006 оны 7-р сарын 30. Монгол тауны ойролцоо Илчиру-уга салбар бүтэн сайн өдрийн үйлчилгээ эхэлсэн.
- Бүтэн сайнд 10:00-16:00 хүртэл банкны ажилтан 2, хамгаалагч 1, орчуулагч 1.
- Гадна хэсэг, үйлчлүүлэгчийн танхимд зарлал нааж, монгол хэл дээх танилцуулга, дурсгалын бараа өгч, Монгол Таунтай харилцаатай болсон.
- Мөнгөн гуйвуулгын шимтгэл 5400→5000 вон болсон.
- 2006 оны 8-р сард Шинхан банкны захирал Монголд айлчилсан.
- 2006 оны 10-11-р сард ХААН банкт Харилцан ойлголцлын меморандум байгуулсан: харилцан үйлчлүүлэгчдээ танилцуулах, ажилтан солилцох, мөнгөн гуйвуулгын хамтын ажиллагаа Vostro A/C, мөнгөн гуйвуулгын гэрээ байгуулсан.
- 2006 оны 11-р сард бүтэн сайн өдөр мөнгө гуйвуулах ажлыг компьютержүүлж, монголын холбогдох хүмүүсийг урьсан.
- 2006 оны 12-р сард ХААН банкны данс нээх үйлчилгээ эхэлсэн.
- 2007 оны 2-р сард ХААН банкны ажилчдыг тухайн банкинд дадлагажигчаар авсан. (1 жилд 4 хүн, ажлын байран дахь сургалт (ОJT), амьдрах байраар нь хангаж)
- 2007 оны 5-р сард Монгол тауны урд салбар нээсэн.
- 2007 оны 6-р сард Монголын нийгмийн даатгалын газартай гэрээ, Анод банкт харилцан ойлголцлыг меморандум байгуулсан.
- Тухайн банкны Монгол руу мөнгө гуйвуулагч шилдэг үйлчилгээний ажилтан 5 хүн ХААН банкинд дадлага хийсэн.
- Монголын нийгмийн даатгалын газартай холбогдох үйл ажиллагааны одоогийн байдал
- Гадаадын оршин суугч дотоодын иргэнтэй адилаар тэтгэвэрийн даатгал төлөгч байх,
- Гэрээнд үндэслэн нэг удаа буцаан мөнгө олгож болох улсууд: Америк, Канад, Герман гэх зэрэг,
- Харилцан ойлголцох зарчимд тулгуурлан мөнгө төлж болох улс: Филиппин, Малайз, Гон-конг, Казакстан, Энэтхэг, Индонези, Тайланд, Нигер гэх зэрэг,
- Буцаан олгох мөнгийг авч чадахгүй улсууд: Монгол, Хятад, Узбекистан,
- 4-р сард тэтгэвэрийн хуульд өөрчлөлт - өөрийн улсад төлөгч байж болох,
- Эх орондоо буцсан 6000 хүний тухайд буцаан ажиллуулах боломжтой,
- Бүтэн сайн өдрийн мөнгөн гуйвуулгын байдал 1983 удаа, 2 сая 300 мянган доллар
- 2006 оны нийт монгол руу хийсэн гуйвуулга 888 удаа, 27 сая доллар
- 2007 оны эхний хагас гуйвуулсан мөнгө 3473 удаа, 13 сая доллар (Шинхан банк 20%, Корейн Эксчэнж 20%, Күкмин 5% орчим)
- 2007 оны 8-р сард Үонгуг хороонд валют солих төв шинээр нээгдсэн.
- Ансан хотын Үонгуг хороонд хилгүй тосгон (гадаад хүмүүийн гудамж) дотор валют солих мэргэжлийн салбар – гадаадын 20000 хүн амьдарч буй бүс нутаг

- Валют солих, мөнгө гуйвуулах төвлөрсөн ажил: ажлын өдрүүдэд 10:30-19:30, бүтэн сайнд 10:30-16:00
- Глобал АТМ, сурталчилгааны материал ба зааварчилгааг гадаад хэл дээр гаргах,
- Хятадын бүс нутагт гадаадын үйлчилгээн салбарт ажилтан томилж ажиллуулах,
- Гадаад хүмүүсийн тусгай тэмдэглэлийн дэвтэр, олон улсын утас, мөнгөний автомат, интернэт утас, утаснаас мөнгө шилжүүлэх үйлчилгээ зэрэг.

Ийм бүтцийн системд төдийгүй виз байхгүй л бол солонгос банкинд данс нээлгэж чадахгүй эх орондоо мөнгө гуйвуулахын тулд “солилцогч”²¹-ийг хэрэглэх болдог. Эцэс төгсгөлгүй гадаадын ажилчдын хууль бус мөнгөн гуйвуулга нь эх орондоо байгаа гэр бүлийнхэнд нь багаахан ч мөнгө илгээж өгч байгаа “солилцогч”-ийг өнгөрөөж хар тамхи ба террор, утасны залилан мэхлэлт зэрэг зохион байгуулалттай гэмт хэргийн мөнгөний зам ба жижиг дунд экспортын компанийн татвараас зайлсхийх арга хэрэгслээр урвуулан ашиглагдах нийгмийн бэрхшээлийг үүсгэж байна. Мөн “солилцогч”-ийн адил хууль бус гуйвуулга нь татвараас зайсхийх ба гэмт хэрэгт ашиглагдаж болох түгшүүр байна. (Күкмин илбу, 2007.2.5)

Мөнгөн гуйвуулгын хэмжээний тухайд Солонгос банк 1 жилээс доош амьдарсан гадаадын ажилчдын гадагшаа гуйвуулгын мөнгөний хэмжээ нь 2006 онд 140 сая доллар (131 тэрбум вон) байна гэж мэдэгдсэн. Харин нэг жилээс дээш байсан ажилчдыг нь оршин суугчаар авч үздэг болохоор тусад нь мэдээллийг түүгээгүй учраас тодорхой тоон хэмжээг нь мэдэхгүй ч хамгийн багаар 1 тэрбум доллараас дээш байх гэж таамаглаж байна.

Ийм хууль бус гуйвуулгыг илүүд үзэх нь дотоодын банкны гуйвуулгын шимтгэл хэт их байгаагаас юм. Түүнчлэн хүмүүнлэг түвшинд ч дотоодын банк нь гадаадын ажилчдын мөнгөн гуйвуулгын шимтгэлийг багасгах зэрэг системийг бодож үзэх хэрэгтэй.

3. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ ба банкны хамтын ажиллагаа

3.1. Гадаадын ажилчдад зориулсан банкны үйлчилгээ

Дотоодын банкныхан энэ хугацаанд санхүүгийнхний нүдэнд өртөөгүй хуримын цагаачлагч ба гадаад ажилчдын төлөө бүтэн сайн өдөр ч мөнгөн гуйвуулга хийх боломжтойгоор үйлчилгээг өргөжүүлж байна. Голдуу монгол, филиппин зэрэг хилийн чанадаас ирсэн гадаадын ажилчид ба амралтын өдөр

²¹ Солилцогч гэдэг нь Хуанчиги гэсэн солонгос үг бөгөөд солонгост амьдарч байгаа гадаадын ажилчид брокер А-д мөнгийг өгвөл А нь гадаадын брокер В-тэй холбоо барьж, ажилчны гэр бүлд тухайн улсын мөнгөөр төлбөр хийж байгаа арилжааг хэлнэ. Бодит хилээс гарч байгаа гадаад валютын арилжаа байхгүй учраас гуйвуулгын шимтгэл бага хугацаа хурдан гадаадын ажилчдын хууль бус гуйвуулгын арга

ч ажил хийх хэрэгтэй гэх бизнес эрхлэгчдэд зориулан үйлчилгээг өргөтгөх хэрэгтэй.²²

Кореан Эксчэнж банкны гадаадын ажилчдад зориулсан 40 салбарын 7 нь бүтэн сайнд үйлчилгээ хийдэг. 7 дах жилдээ хятадын солонгосуудад зориулан бүтэн сайнд үйлчилгээ үзүүлж ирсэн Сөүлийн Тэримёг салбар, индонези ажилчдын үйлчлүүлж дадсан Кёнги Ансан Уонгуг хорооны салбар, филиппины ажилчин үйлчлүүлэгч олонтой Ийжонбу салбар, шриланка, тайланд, ажилчид ихтэй Кимпо салбар, монгол ажилчид ихтэй Сөүл Түигеру салбар, Илсаны Тэхуаёг салбар, Юнин салбарууд гадаадын ажилчдад зориулан бүтэн сайнд үйлчилгээ үзүүлж байна. Кореан Эксчэнж банк утсаар гадаад гуйвуулга хийх боломжтой, “Мубайл банкинг” үйлчилгээг гаргаж, мэдүүлэг бөглөхгүй төвөг багатайгаар гадаадад мөнгөн гуйвуулга хийх боломжтой, гуйвуулгын картны үйлчилгээг хэрэгжүүлж байна. Үри банкны Сөүл Хехуа хорооны салбар бүтэн сайны үйлчилгээнээс гадна гадаадын ажилчдын бэрхшээлтэй асуудлуудын талаар зөвлөлгөө өгөх төвийг ажиллуулж байна. Нунхёб банк сүүлийн үед хуримын цагаачлагч гадаадын эмэгтэйчүүд нэмэгдэж байгаатай холбогдуулан “Төрсөн эцэг эхийн холбоо тогтоох”, “Солонгос хоол хийж сурах”, “Хүүхдийг дэмжих” зэрэг тусламжийн арга хэмжээг явуулж байна.

Долоо хоног бүрийн бүтэн сайн болоход Сөүлийн Хехуа хороо Хехуа сүмийн филиппин номлогчийн Мисса цуглаанд оролцохын тулд солонгост амьдарч байгаа филиппин ажилчид ар араасаа цугларан “Жижиг Манилла”-гаар солигддог. 2000 орчим филиппин ажилчид Хехуа хороонд цугларсны 250 орчим нь гэртээ мөнгө илгээх буюу валют солихын тулд Үри банкны Хехуа салбар ба филиппины Метро банкны Сөүлийн салбарт очдог. Үри банк нь филиппин үйлчлүүлэгчдийн төлөө долоо хоног бүрийн бүтэн сайн өглөө 10:00 цагаас оройн 16:00 цаг хүртэл ажилладаг.

Үүнээс гадна Франц тосгон бий болсон Сөүлийн Сочү дүүргийн Соре тосгонд Шинхан банкны Панбусоре салбар байдаг, Шинхан банкны Ичун дүүргийн салбар нь япон оршин суугчид өргөнөөр үйлчлүүлдэг газар бөгөөд, хятадын солонгосуудын ба хятадууд ойр байдаг Гүру Кореан Эксчэнж салбар нь хятадуудын мэргэжлийн банкны үйл ажиллагаа явуулж байна. (Мэйл Кёнжэ, 2007.8.4; Нэйл шинмүн 2007.8.13)

2006 он хүртэл хууль бусаар амьдрагчдын хувьд цалингийн мэдүүлгийн хуудсыг бөглөж чадахгүйгаас банкны гуйвуулгыг огт хэрэглэж чадахгүй байснаас брокерт хандахаас өөр арга байсангүй. Гэвч брокерын гуйвуулгыг явцад хохирол гарахад буцаан авч чадахгүй, ихэнх нь “солигч” (банкаар

²² Энгийн хүмүүст ажлын өдөр хамгийн ойр үйлчилгээг үзүүлж байгаа газар нь Хана банкны Мёндуна дахь салбар юм. Мёндуны үйлчилгээний салбар нь хагас бүтэн сайн, баярын өдрүүдэд өдөр 12 цагаас орой 19:30 хүртэл, ажлын 5 өдөрт орой 17 цагаас 21:30 хүртэл онгорхой байдаг.

дамжуулалгүй хоёр улсын хооронд гуйвуулга хийж байгаа мөнгө угаах аргын хэлбэр) –ыг хийж байгаа учраас бэрхшээл их байсан.

Дотоодод байгаа гадаадын хууль бусаар амьдрагчид банкаар дамжуулах хууль ёсоор гуйвуулга хийх болсноор “солилцогч” зэрэг хууль бус гуйвуулга нь ихээр багассан. Санхүү эдийн засгийн яам нь дотоодод оршин суугч гадаадын иргэд гадаад руу мөнгөн гуйвуулга хийхдээ ажлын газрын үнэмлэх ба цалингийн тодорхойлолтыг заавал гаргаж үзүүлдэг байсан гадаад валютын арилжааны журмыг засч нэг удаа 1000 доллароос илүү, жилд 20000 доллараас дээш явуулах нөхцөлд дээрх баримт бичгийг үзүүлэхээр өөрчлөгдсөн. (2006.9.7) Ялангуяа гадаад паспортын хүчинтэй хугацаа нь дуусаагүй ч визээ сунгаж чадаагүй шалтгаанаар хууль бусаар амьдрах болсон ажилчид ч банкаар дамжуулан гадаад гуйвуулга хийж чадах зам нээгдсэн. Мөн ажлын газрын үнэмлэх ба цалингийн тодорхойлолт авахад хэцүү хялбар ажлууд хийж байгаа гадаадын ажилчид банкыг ашиглаж чадах болсон. Бага хэмжээний гуйвуулга нь ажиллаж байгааг батлах бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагагүй гадаад паспортны хүчинтэй хугацаа л баталгаатай тохиолдолд хууль бусаар амьдрагч гадаадын ажилчид хууль ёсоор банкаар дамжуулан эх орондоо мөнгөн гуйвуулга хийж чадахаар байна.

3.2. Монгол ажилчдын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

Дээрх хугацаанд монголын хууль бус ажилчд өөрсдийн мөнгөө гуйвуулж байсан арга нь 5% шимтгэлтэй ч брокерыг дамжуулах зам төдий байсан. Харин одоо банкны гуйвуулгын арилжаанд хууль бусаар ба хууль ёсоор амьдарч байгаа бүгд ялгаагүй болж бүртгэлгүй ажилчид банкинд гадаад паспортоо ч үзүүлвэл 1 удаад 1000 доллар, 1 жилд 20000 долларыг ямар ч хориггүйгээр гуйвуулж чадах болсон.

Арилжааны банк нь 2006 оны 8 сараас бүртгэлгүй гадаадын ажилчдад ч мөнгөн гуйвуулгыг хийж өгч байгаа боловч, жил ирэх тутам брокерыг дамжуулсан гуйвуулга өсч байна. Яагаад гэвэл банк руу явж байгаад баривчлагдаж буцах байх гэсэн түгшүүрээс болж банкинд ийм үйлчилгээ байгааг ч мэдэхгүй гадаад ажилчид олон байгаа юм. Монгол таун байдаг Сөүлийн Тундемүний ойр орчимд ийм банкнууд байдаг. Монгол улсын ерөнхийлөгч Намбарын Энхбаяр 2006 оны 5 сард Ну Мү Хён ерөнхийлөгчийг айлчлахад солонгост байгаа монгол ажилчид банкны үйлчилгээний цагийн хуваариар банкаар үйлчлүүлэх хэцүү байгаа бодит нөхцөл ба хууль бус гуйвуулгын асуудлыг шийдвэрлэж өгөхийг албан ёсоор хүссэн юм. Үүний дагуу 2006 оны 8 сард Санхүү эдийн засгийн яамны сайдын мэдээллээр хууль бусаар амьдрагчдын мөнгөн гуйвуулга ч нэг удаад 1000 доллар, жилд 20000 доллар гэсэн хүрээнд зөвшөөрөгдөх болсон.

Сөүлийн Монгол тауны ойролцоох Күкмин банк (Учан салбар), Шинхан банк (Илчиру уга салбар), Кореан Эксчэнж (Түигеру салбар) банкнууд бүтэн сайн

өдрийн үйлчилгээгээр 30000 монгол ажилчинд зориулсан мөнгөн гуйвуулгыг хийх үүргийг хүлээгээд байна. Күкмин банкны Учан дүүргийн салбар нь “Монголд хэдэн зуун доллар орчим бага хэмжээний гуйвуулга хийдэг үйлчлүүлэгч олон байдаг” гэсэн бөгөөд “шимтгэл найрсаг үйлчилгээнээс эхлээд солонгос хэлэнд муу монгол ажилчдын төлөө солонгос ба монгол хэлээр чөлөөтэй ярьдаг монгол ажилтан ажиллуулж байна” гэжээ. Үйлчилгээгээ эхлээд 1 жил орчим болж байгаа Күкмин, Шинхан банкинд бүтэн сайн өдөр хамгийн ихдээ 130 хүн орчим болдог монгол ажилчид хөдөөнөөс ч зорин ирж үйлчлүүлдэг байна. Шинхан, Корейн Эксчэнж салбаруудад монголоос ХААН банкны ажилтнууд томилолтоор ажиллаж байна. Күкмин банк ч орчуулагчийг ажиллуулан үйлчилгээнд нь тусалж байна.

Монгол ажилчид 3 салбарыг дамжуулан жилд Монгол руу гуйвуулах мөнгөний хэмжээ нь 12 тэрбум вон юм. Энэ нь дотоодын салбартай харьцуулахад бага хэмжээ бөгөөд одоогоор их ашиг байхгүй боловч нийгэмд хувь нэмрээ оруулах талаар үр ашигтай байна.

Солонгос дахь монгол ажилчид хууль бус 10 мянга орчим хүнийг оруулаад нийт 28 мянга орчим хүн байна. Эдгээр нь сард 1 сая вон орчим цалин авч үүний 500-600 мянган воныг өөрийн орон луу гуйвуулж байна. Эдгээр хүмүүсийн монгол руу гуйвуулж байгаа мөнгө нь жилд 300 сая доллар орчим бөгөөд монголын ДНБ (1 тэрбум 870 сая доллар – 2005 оны байдлаар)-ий 16% орчим болж байна. Монгол дахь ажилчдын дундаж цалинг 250 мянга орчим гэдгийг тооцож үзвэл их мөнгө юм.

Монгол мөнгөн гуйвуулгыг төлөөлөгч салбар Корейн Эксчэнж банкны Түигеру салбар Сөүлийн Чүнгү Куанхи хороонд Монгол тауны орох замд байдаг. Монгол тауны ойролцоох банкны салбарууд монгол ажилчдын эх орондоо мөнгө гуйвуулга хийхийг хадгалахын тулд өрсөлдөөн ихтэй байна. Корейн Эксчэнж банкны урд Күнмин банкны салбар, Шинхан банкны салбар зэрэг нь монгол ажилчдын төлөө бүтэн сайн өдөр үйлчилгээ хийж байна. Гэвч одоо хүртэл хангалттай тооны монгол хүмүүс банкыг биш хууль бус брокерыг дамжуулан өөрийн орондоо мөнгө гуйвуулж байна. Корейн Эксчэнж банк сүүлийн үед 600 гадаад ажилчдыг хамруулсан судалгаа хийсний үр дүнгээс харвал монгол хүмүүсийн банкаар дамжуулан хийсэн гуйвуулга нь 20% орчим байгаа нь гадаадын ажилчдаас банкаар хамгийн бага үйлчлүүлж байгаа юм. Мөнгөн гуйвуулгын брокер нь бага хэмжээний мөнгийг явуулахдаа 2% -ийн шимтгэлийг авдаг бөгөөд ганц удаа утсаар ярихад нь хэдхэн цагийн дотор бүр бүлд нь мөнгийг хүргэж өгдөг.

3.3. Бусад санхүүгийн үйлчилгээ

Корейн эксчэнж банкны гадаадын ажилчдад зориулсан санхүүгийн үйлчилгээ нь дараах байдалтай байна. Үүнд:

1. Ослын даатгалд төлбөргүй орох үйлчилгээ: Валютын солилцооны найрсаг байдал байхгүйгээр 500 ам.доллараас дээш валют солих нөхцөлд 1 сарын даатгалын хугацаанд осолд орвол дээд тал нь 10 сая вон хүртэлх нөхөн төлбөр.
2. Үнэгүй олон улсын ярианы үйлчилгээ: Гадаадын ажилчин өөрийн орон луу 3 минут үнэгүй ярина. Гол үйлдвэрийн цогцолборын бүсүүдэд багтаж байгаа улс даяарх 100 орчим үйлчилгээний газруудад хийж байна.
3. Шинэ аянга гуйвуулгын үйлчилгээ: Гадаадад мөнгө гуйвуулснаас 30 минутын дараа гуйвуулгын хүлээн авах боломжтой. Үйлчилгээнд хамрагдах улсууд: Хятад, фипиппин, индонез, вьетнам зэрэг 8 улс, 10 мянган ам.долларын дотор бол тус бүрдээ шимтгэл нь 10 доллар.
4. Гадаадын ажилчдад зориулсан бүтэн сайн өдрийн үйлчилгээ: Бүтэн сайн өдөр болон ажлын өдрийн ажлын цагаас хойш оройн цагаар гуйвуулга хийж гадаадын ажилчдын ая тухтай нөхцлийг хангаж байна. Тэримёг, Үонгугдун, Тэхуаёг, Ыжонбү, Кимпу, Юнин, Түигеру салбар, цаашид хөдөө орон нутагт салбаруудыг нээх гэж байгаа
5. Ажиллах зөвшөөрөлтэй холбоотой түншийн банк: Ажиллах зөвшөөрлөөр орж ирсэн ажилчдын эрүүл мэндийн даатгалын хураамж, шилжүүлэг ба даатгалын мөнгийг хүлээн авах данс, картыг хийсэн. Солонгосын үйлдвэрийн ажиллах хүчний төв, Олон улсын хөдөлмөрийн хамтын ажиллагааны газар, Самсун хуаже зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
6. Гадаадын ажилчдын гарын авлагыг үнэгүйгээр хуваарилж байна. 8 улсын хэл ба солонгос хэлээр гаргасан санхүүгийн арилжааны гарын авлага, харилцааны журмын гарын авлага, солонгосын амьдралд заавал хэрэгтэй мэдээлэл зэргийг нийтэлсэн. Банкны арилжааны талаас бүх арилжааны холбогдох дугаарыг тодорхой бичиж хэл мэдэхгүй ч дугаарыг нь мэдвэл Корейн Эксчэнжийн ажилтнууд үйлчилгээг хийж дуусгана.
7. Гадаадын ажилчдын өөрийн орны банк ба илгээгч сургалтын байгууллагын уялдаатай ажиллагааг өргөжүүлж байна. Монголын ХААН банк ба улсын нийгмийн даатгалын газартай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, хамтын үйлчилгээг хийж байна. Филиппиний Хөгжлийн банк ба Шриланкийн Цайлон банкттай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.
8. Гадаадын ажилчдыг дэмжих төв ба засгийн газрын байгууллагуудтай хамтран гадаад ажилчдын наадмыг ивээн тэтгэж байна. “Мигрантс Ариранг” 3 дахь цуглааныг үргэлжлүүлэн 2005 онд 6 цуглаан, 2006 онд 12 цуглаан, 2007 онд 28 наадмын арга хэмжээг дэмжиж хийсэн.
9. Тухайн орны хүнийг ажилд авах үйлчилгээг хийж байна. Хятад,

индонез, монгол, шриланк зэрэг тухайн орны хүнийг Кореан Эксчэнжийн салбаруудын ажилтнаар авах ба хамтын ажиллагаатай банкнуудын ажилтнуудыг томилолтоор ажиллуулж байна.

10. Гадаадын ажилчдын тусгай бүтээгдэхүүний үйлчилгээг хийж байна. Кореа мөрөөдлийн утас (Korean Dream Phone), гуйвуулгын бага шимтгэл, найрсаг валютын солилцоо ба хямд олон улсын ярианы боломжийг олгож байна. Хялбар утас (easy phone) үйлчилгээ (банк руу явахгүйгээр мөнгө шилжүүлэх) ба картаас гадаадад мөнгө шилжүүлэх үйлчилгээ (Кореан Эксчэнж ба АТМ-ээс мөнгө гуйвуулах) зэргийг хийж байна.

3.4. Тэтгэвэр төлөхөөс чөлөөлөх нь

Бүртгэлтэй ажилчдад “Гадаад ажилчдыг хөлслөхтэй холбоотой хууль”-ийн дагуу солонгост байх хугацааны даатгал ба амь даатгал, буцах зардлын даатгал, ослын даатгал гэсэн 4 даатгалд хамрагдах ёстой. Энэ хугацаанд хөгжиж байгаа орнуудын ажилчид үйлдвэрийн дадлагажигчийн хугацаагаа дуусган эх орондоо буцахдаа энэ хугацаанд төлөх тэтгэвэрийн даатгалын төлбөр (нэг удаа буцаан олгох)-ийг буцаан авч чадахгүй. Гадаадын иргэдийн тэтгэвэрийн даатгалд төлсөн мөнгийг буцаан төлөлт нь тэтгэвэрийн хуульд үндэслэн харилцан ойлголцол ба хоёр улсын хоорондхи нийгмийн хамгааллын хэлэлцээрт үндэслэж шийдвэрлэгдэн, солонгос ажилчдад нэг удаа буцаан олгож байгаа улсуудын ажилчдад л буцаан олгосон. Иймээс хятад, монгол зэрэг нөхцөл тааруу улсуудаас ирсэн үйлдвэрийн дадлагажигч ба ажиллах зөвшөөрөлтэй гадаадын ажилчид нь энэ хугацаанд төлсөн даатгалын шимтгэлийн буцаан авч чадаагүй.

Ну Мү Хён ерөнхийлөгч ба Энхбаяр ерөнхийлөгчийн дээд хэмжээний уулзалтын үр дүнд монгол ба манай улсын хооронд 2006 оны 5-р сарын 8-ны өдрийн нийгмийн хамгааллын хэлэлцээрт үндэслэн даатгалын татвараас чөлөөлөх хэлэлцээр (богино хугацааны хэлэлцээртэй улсуудад томилогдсон ажилчид өөрийн орны тэтгэвэрийн даатгалд хамрагдан томилогдсон улсаасаа татвараас чөлөөлөгдөх хэлэлцээр) байгуулсан. 2007 оны 3 сарын 1-ний өдрөөс хэлэлцээр хэрэгжих болж монгол ажилчид монголын тэтгэвэрийн даатгалд шимтгэл төлөхөөр болж, монголын тэтгэвэрийн даатгалаас чөлөөлөгдсөн. (Файниншиэл ньюс, 2007.2.28)

Үүний дагуу дотоодын жижиг үйлдвэрийн эздийн санхүүгийн хариуцлага нь жил бүр 4 тэрбум воноор багасах болсон. Мөн монгол руу томилогдох ажилчид монголын тэтгэвэр ба ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг төлөхгүй байж болох, унгарт байгаа солонгос ажилчид унгарын нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхгүй болсон. Нийгмийн даатгалын хэлэлцээр нь тэтгэвэрийн даатгалын системд гадаадын иргэд ба гадаадад амьдрагчидын таагүй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд улс хооронд байгуулж буй

гэрээгээр дотоодын хуультай адил хүчин төгөлдөр явуулж байна.

Үйлдвэрийн дадлагажигч, гэрээний ажилчны эрхтэйгээр солонгост ажиллаж байгаа монгол ажилчин 6529 (2007 оны 1 сар) тэтгэвэрийн даатгал ба ажиллах хугацааны даатгалын шимтгэл төлөхгүй байж болно. Мөн монголд томилогдсон солонгос ажилчин 450 хүн монголын тэтгэвэрийн ба ажилгүйдлийн даатгалыг төлөхгүй болж жил бүр 766 сая воныг хэмнэсэн.

Одоо солонгос нь монгол, унгараас эхлээд иран, канад, англи, америк, герман, хятад, нидерланд, япон, итали, узбекистан зэрэг 12 улстай нийгмийн даатгалын хэлэлцээр хэрэгжиж байна.

3.5. Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр ба санхүүгийн үйлчилгээний сургалт

Кореан Эксчэнж банк ХААН банктай хамтын маркетингийн тухай харилцан ойлголцлыг меморандумыг байгуулсан (2007.3.22). Энэ удаагийн хэлэлцээр 2006 оны 9 сард хоёр банкны хооронд валютын арилжааны хэлэлцээрийг байгуулж мөнгөний төлбөр тооцоо дуусгахад хэрэглэх дансыг нээн нь солонгост амьдарч байгаа 30 мянган монгол ажилчдад таатай санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Үүний хамт 3 сарын 20-нд монгол ажилчдын тэтгэвэрийн даатгал төлөх ба монгол руу гуйвуулга хийхтэй холбогдуулан улсын нийгмийн даатгалын газартай ажил үүргийн хэлэлцээр байгуулсан. Үүний дагуу монгол ажилчид Кореан Эксчэнж банкны дансаар дамжуулан тэтгэвэрийн даатгалаа төлж, компанийн электрон санхүүгийн үйлчилгээг ашиглан Монгол руу шилжүүлэг хийж чадах систем шаардлагатай болсон. Кореан Эксчэнж банк гадаадын ажилчдын бүс нутаг, цаг хугацааны хязгаарлалыг тооцоолон АТМ зэргийг дэлгүүр, метроны бэлэн мөнгө хийж, авагч зэргээс гуйвуулга хийж болохоор хийж, 2006 оны эцэст Элжи телеком, Фи ай тел-ийн холбоог дамжуулан гар утаснаас гуйвуулга хийх ба кореан дрим фоныг хөгжүүлэх зэргээр гадаадын ажилчдын таатай байдлыг дээшлүүлж ирлээ. Солонгост бүртгэлтэй гадаадын ажилчид “Гадаадын ажилчдын ажил эрхлэхтэй холбоотой хууль”-ийн дагуу 4 төрлийн даатгал төлөх ёстой боловч хууль тус бүр ямар ашиг тустайг нь сайн мэддэггүй. Эдгээрийн нэг болон ослын даатгал нь байрандаа унтаж байгаад нас барсан зэрэг ажил гүйцэтгэж байсан бус тохиолдолд дээд тал нь 30 мянган нөхөн төлбөр олгодог боловч даатгалын тухай ойлголт муугаас авч болох нөхөн төлбөрийг ч авч чадахгүй буцах тохиолдол үе үе байна.

Гадаадын ажилчдын санхүүгийн хэрэглээнд тусалж солонгост суурьшихад нь туслахын тулд солонгосын гадаадын ажилчдыг дэмжих төв санхүүгийн хяналтын газартай хамт санхүүгийн сургалт ба иргэний зөвлөлгөө өгөх ажлыг хэрэгжүүлж байна. Энэ санхүүгийн үйлчилгээний сургалт нь урт биш хугацаанд хэрэгжинэ. Хоёр дахь удаагийн сургалт дараах байдлаар

гүйцэтгэгдсэн.

Гадаадын ажилчид ба зөвлөлгөө өгөгчдөд зориулсан сургалт явуулах зарлал

Гадаадын ажилчдын санхүүгийн асуудалд туслах, дотоодод суурьшихад нь туслахаар солонгосын гадаадын ажилчдыг дэмжих төв санхүүгийн хяналтын газартай хамт санхүүгийн сургалт ба иргэний зөвлөлгөө өгөх ажлыг дараах байдлаар хэрэгжүүлэхээр газаадын ажилчид, цагаач гэр бүл болон холбогдох ажилтнуудыг өргөөнөөр оролцохыг хүсч байна.

Хугацаа: 2007.11.11 (Бүтэн сайн) 13:00-17:00

Оролцогчид: Хотын оршин суугч гадаадын иргэд, гадаадын ажилчидтай холбогдох тусламжийн байгууллагын ажилтнууд

Байрлал: Солонгосын гадаадын ажилчдыг дэмжих төв

Сургалтын агуулга:

- Банк, санхүүгийн байгууллагыг ашиглах ба мөнгө солих, гуйвуулга хийх
- Гадаадын ажилчдыг дотоодын даатгалд хамруулах ба нөхөн төлбөрийн жишээ

Иргэний зөвлөлгөө:

- Банк, даатгал, холбогдох санхүүгийн хохирлын зөвлөлгөө
- Ерөнхий хуулийн зөвлөлгөө

Эх сурвалж: : Солонгосын гадаадын ажилчдыг дэмжих төв

<http://www.migrantok.org>

4. Санхүүгийн үйлчилгээний бэрхшээлүүд, хэрэгжүүлэх арга хэмжээ

Монголын ХААН банк нь солонгосын Күкмин, Шинхан, Кореан Эксчэнж гэсэн 3 банктай холбоо тогтоон хамтран ажиллах байна. Солонгост ажилчид нь монгол руу хямдаар гуйвуулга хийж, солонгосын дээрх 3 банкнаас ХААН банкинд хадгаламж нээж байна. Күкмин, Шинхан, Кореан Эксчэнж банкнаас монголын ХААН банк руу гуйвуулга хийвэл шимтгэл нь харьцангуй хямд, гуйвуулгын хэмжээ 2000 доллар хүртэл шимтгэл нь 5000 вон, 2000 доллараас дээш бол солонгосын банкны гадаадад гуйвуулга хийдэг шимтгэлээр гуйвуулна. Кореан Эксчэнж банк нь гуйвуулгыг хамгийн хямд шимтгэлээр тогтоож хадгаламж нээж байна. Гадаад валютын 1 жилийн хугацаатай хадгаламжийн хүү 5.1% бөгөөд 1 жилийн дотор 4 удаа мөнгийг авч болно. Мөн вонын 1 жилийн хугацаатай хадгаламжийн хүү 4.8% бөгөөд энэ хугацаанд 4 удаа мөнгө авч болно. Энгийн хадгаламжийн хүү нь 1.3% байна.

Монгол руу гуйвуулга хийх боломжтой банкнууд нь Худалдаа хөгжлийн банк, Монгол шуудан банк, Анод банк, Голомт банк, Кредит банк болно. ХААН банк нь солонгост төлөөлөгчийн газраа 2007 оны 11 сарын 23-нд нээсэн. Энэ салбар нь солонгосын эдийн засаг, банк санхүүгийн зах зээлийн

мэдээлэл, санхүүгийн үйл ажиллагааны тухай мэдээллээр хангах зэрэг ашгийн бус үйл ажиллагаа явуулна. Монгол ажилчид солонгост ажиллаж амьдрангаа солонгосын Кореан эксчэнж ба Шинхан банкаар дамжуулан монголд 420 орчим салбартай ХААН банкинд мөнгөө хадгалах боломжтой болсон. Кореан эксчэнж ба Шинхан банкны гуйвуулгыг дамжуулан ХААН банкинд хадгаламжийн дэвтэр нээн хэрэглэж болно. ХААН банкнаас 25 сая төгрөг (худалдан авах байрны 70%, 20 вон) орчим төлөөд зээлийн хүү нь хадгаламжийн хугацаа болон хүүгээс шалтгаалан өөрчлөгдөх боловч ерөнхийдөө 1 жилд 11.9-21% юм.

Солонгосын банк ба монголын банкны харилцааны эхэн үед хэрэглэгч цөөн байсан бөгөөд 3 сараас эхлэн нэмэгдэж байна. 2007 оны 11 сарын байдлаар солонгост 28 721 хүн амьдарч үүний 25 мянга орчим нь ажил хийж байна. Үүнээс хууль бусаар амьдарч байгаа нь 60%, хууль бусаар амьдарч байгаа нь 40% орчмыг эзэлж байна. Эдгээр хүмүүсийн дундаж цалин нь 1 сая вон бөгөөд банкыг дамжуулан гуйвуулга хийх байдлыг харвал долоо хоногт Кореан эксчэнж банкинд дунджаар 100-110 хүн, Шинхан банкинд 60-70 хүн, Күкмин банкинд 10 хүн орчим байна. Гуйвуулгын хэмжээ нь дунджаар 800 000-1 сая вон орчим.

Монголын мөнгөн гуйвуулгатай холбоотой одоо үүсээд байгаа бэрхшээлүүд дараах байдалтай байна. Үүнд:

1. Солонгосын хууль, журмыг дагавал солонгост байгаа гадаадынхан солонгост байх хугацаандаа 10 мянга хүртэл доллар гуйвуулах боломжтой. Гэвч монголчуудын нэг сарын дундаж орлого нь голдуу 1 сая гэж үзвэл мөнгө гуйвуулах зөвшөөрөгдөх хэмжээ маш бага.
2. Хууль бус ажилчид солонгосын банкинд хадгаламж нээж чадахгүйгээс олон янзийн асуудлууд үүсч байна. Жишээлбэл: Солонгост хадгаламж байхгүй учраас монгол дах итгэлтэй хүмүүстэй мөнгөө илгээж тэдгээр хүмүүс нь хадгалж чадахгүй бүгдийг үрж дуусгаж байна. Одоо ХААН банктай солонгосын банкууд холбоо тогтоон энэ асуудлыг шийдэж өгч байгаа боловч гуйвуулгын хэмжээний хязгаарлалтаас болж энэ бэрхшээл үргэлжилсээр байна.
3. Солонгосын банкнуудыг дамжуулан гуйвуулга хийж хадгаламж нээж байгаа хүн заавал иргэний үнэмлэх байх шаардлагатай учраас солонгост гадаад паспорт болон иргэний үнэмлэхгүй иргэд их байгаагаас үйлчилгээг авах боломжгүй байна.
4. Сөүлд байгаа хүмүүс монгол ажилтантай салбарт ирдэг боловч хөдөө орон нутагт ажиллаж байгаа хүмүүс солонгос хэл мэдэхгүйн улмаас банк руу явж чаддаггүй.
5. Монголоос дадлагажигчаар ирж байгаа монгол хүмүүс гадаад паспортыг ажиллаж байгаа байхгүйн улмаас банкинд ирж чаддаггүй бэрхшээл байна.

Монгол ажилчдын мөнгөн гуйвуулгын асуудал шийдэгдсэн боловч мөнгөн гуйвуулгын үр дүнтэй ашиглалт ба хяналтын бодлого боловсруулах шаардлагатай. (Шим Ы Соб, Мөнхнасан). Гадаадад ажиллаж буй монгол ажилчдын эх орондоо мөнгө гуйвуулсан мөнгө нь монголын эдийн засагт нэмэр болж байгаа ч мөнгөн гуйвуулгын бодит үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөнгийг аваад голдуу хоол хүнс, хувцас, эм эмчилгээ, сургалтын төлбөр зэрэг амьжиргааны зардалд зарцуулж үл хөдлөх хөрөнгө авах ба санхүүгийн төлбөрүүд хийж байна. Мэдээж ховор тохиолдолд бөгөөд бага хэмжээтэй боловч үр ашигтай хөрөнгө оруулалтын жишээнүүд ч байна. Мөнгө гуйвуулж байгаа ажилчин ба монгол дахь гэр бүлийнхэн нь мөнгийг ашиглаж удирдах арга дадлагагүй, ийм бэрхшээлүүдийг шийдвэрлэх монголын банкнуудын туршлага ч мөн дутмаг байна. Иймээс монгол солонгосын хоорондхи банкны хамтын ажиллагаагаар дамжуулан монголын эдийн засгийг хөгжүүлэх туршлага судлах, цаашид бодит үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд монгол ажилчдын орлогыг бага мөнгөний санхүү (Крамен, микро банк)-тай адил хянаж чадах Вонын дахин ашиглалт (Korea Won Recycling)-ийн шинэ арга замыг хөгжүүлэхийн тулд хоёр улсын бодлогын хамтын ажиллагаа чухал байна.

Ашигласан материал

Ну Гуан Юн, *Гадаад ажилчдын банкны арилжааны гарын авлага*, Кореан эксчэнж банк, 2007.11.11

Хууль зүйн яамны мэдээлэл, *Оршин суугаа гадаадын иргэд 1 сая хүн давлаа*, 2007.8.24

Шим Ый Соб, Мөнхнасан, *Монголын ажил эрхлэлт ба орлого нэмэгдүүлэх стратеги*, Солонгосын олон улсын хөдөлмөрийн сан, 2007.1.25

Иргэний өдөр тутмын мэдээлэл, *Гадаад ажилчдын мөнгөн гуйвуулга, хууль бус солилцогч*, 2007.2.5

<http://news.media.daum.net/society/affair/200702/05/kukminilbo/v15627343.html>

Өдөр тутмын сонин, *Солонгос олон үндэстний нийгэм руу – 21-р зууны шинэ солонгос хүн хуримын цагаачлагч*, 2007.08.13

<http://cafe.daum.net/immigration/TTc/232>

Өдөр тутмын эдийн засаг, *Хууль бус ажилчид банкнаас хууль ёсоор мөнгө гуйвуулах боломжтой*, 2006.9.7

Өдөр тутмын эдийн засаг, *Гадаадынхны цугладаг банкны салбар*, 2007.08.04

<http://cafe.daum.net/MAIL/3Hzt/1597>

Соёлын мэдээ, *Арьсны өнгө*, 2007.10.02,

<http://www.munhwa.com/news/view.html?no=2007100201034227066003>

Соёлын мэдээ, *Солонгост гадаад хүн 1 сая давж олон үндэстний нийгэмд ойртолоо*, 2007.10.02

<http://www.munhwa.com/news/view.html?no=2007100201034227066003>

Нэгдсэн мэдээ, *Дотоодод оршин сууж байгаа гадаадын иргэн анх удаа 1 сая давлаа*, 2007.8.24

Нэгдсэн мэдээ, *Хэдэн зуун сая вонтой монголын хууль бус банк эрхлэгчийг*

илрүүлээ, 2005.11.9. 2007.07.08

http://article.joins.com/article/article.asp?ctg=12&total_id=2785404

Санхүүгийн мэдээ, *Монгол ажилчид тэтгэвэрийн даатгал төлөхгүй байж болно*, 2007-02-28

<http://cafe.daum.net/gomongol/67yy/57>

Хангёре, *Хууль бусаар ажиллагчид ч банкнаас гадаад руу гуйвуулга хийж болно гэж үү?*,

2007.

11.

12,

http://www.hani.co.kr/arti/economy/economy_general/249576.html

Хангёре, *Мөнгө гуйвуулагч цагаач ажилчид*, 2007.11.23

<http://www.hani.co.kr/arti/international/globaleconomy/252344.html>

Хералд эдийн засаг, Тусгай боломж олон соёл нээлттэй нийгэм, Гадаадынхан байхгүй бол үйлдвэрүүд бүгд зогсоно. 2007.8.17

http://www.heraldbiz.com/SITE/data/html_dir/2007/08/17/200708170086.asp

Би бүтэнд сайнд ч банк руу явдаг. 2007.11.11

<http://cafe.daum.net/re9114/7Wbl/140>

Солонгос дахь монгол ажилчид тэтгэвэрийн даатгалаас чөлөөлөгдөв, 07.03.04

<http://cafe.daum.net/pmaffl/IdOK/1340>

Шинхан банк монгол руу мөнгөн гуйвуулга хийж эхэллээ,

http://cafe339.daum.net/c21/bbs_search_read?gpid=9GOT

Гадаад ажилчид тэтгэвэрийн даатгалд төлсөн мөнгөө буцааж авна, 2007.03.21

<http://cafe.daum.net/woaiyanji/GKpS/605>

Кореан эксчэнж монголын ХААН банктай ажлын гэрээ байгуулав, 2007.03.22

<http://cafe.daum.net/cambodiawedding/AGP9/29>

Манай тосгоны жижигхэн гадаад улс Монгол Таун,

<http://cafe.daum.net/bride1004/3arh/316>

Банкны гадаад ажилчдад зориулсан үйлчилгээний өргөтгөл,

2007.08.02 <http://cafe.daum.net/oklink/6oBQ/7>